

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГСА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас:
70543179 Цахим хаяг:
Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2024 оны 04 дүгээр сар

А Орон нутгийн 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна. 7

1.1. Орон нутгийн 2023 оны төсөвт татварын болон татварын бус 10 нэр төрлийн орлогыг 1,650.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 66.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.7

1.2. Орон нутгийн 2023 орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 18.5% буюу 1,969.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн татварын орлого 366.2 сая, 3 нэр төрлийн татварын бус орлого 43.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.10

.....16

Б Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагыг бодитой тооцоогүй, ОНХС-гийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь төсвийн үр ашгийг бууруулж байна. 16

Б.1 Төсвийн зарлагыг бодитоор тооцож төлөвлөөгүйгээс төсөвт тодотгол хийсэн байна.16

Б.2.2. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй нь төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.19

В Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хэрэгжилт 86.0 хувьтай байна. 21

Г Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 1,605.6 сая төгрөг буюу 47.7 хувь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил 23.0 сая төгрөг буюу 31 хувиар тус тус буурсан байна. 23

Д Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. 25

Дүгнэлт

Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамирын спортын газар
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДНС	Засаг даргын нөөц сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162-р тушаалаар батлагдсан ТАБ-ын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2023 оны төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөн, бүрэн төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн 2023 оны төсвийн зардлыг бодитой тооцож төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулсан эсэх
3. Орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
4. Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан эсэх
5. Өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлсэн эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль,
4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Нийгмийн даатгалын багц хуулиуд
6. Төрийн аудитын тухай хууль
7. Төрийн хэмнэлтийн тухай хууль
8. Татварын багц хуулиуд
9. Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
10. Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Аудитын хамарсан
хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЕЗ-ийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа мэдээлэл болон бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 1000-1800, Төрийн хяналт шалгалтын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах

Хүндрэл бэрхшээл:

аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

“Аймгийн 2023 оны төсвийг тодотгон батлах тухай” 03 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагыг 22,223.8 сая төгрөгөөр баталснаас орон нутгийн төсвийн орлогыг 12,785.0 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 2,378.2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 5,731.5 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 373.9 сая, урьд оны үлдэгдлээс 955.2 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-аар тодотгон баталсан 2,928.2 сая төгрөгийн орлого дээр сумдын ИТХ-аар нэмэгдүүлэн баталсан 7,406.4 сая төгрөг нэмэгдэж, нийт дүнгээр 10,334.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 12,238.2 сая төгрөг төвлөрч төлөвлөгөөг 118.4 хувиар буюу 1,903.7 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Тайлант онд 21 нэр төрлийн орлогоос 10 нэр төрлийн орлого 2,335.6 сая төгрөгөөр давж, 10 нэр төрлийн орлого 431.9 сая төгрөгөөр тасарсан бөгөөд тасарсан орлогын 77.2 хувь буюу 333.8 сая төгрөг нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, малын тоо толгойн албан татвар байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 2023 жилийн эцсийн байдлаар 22,223.8 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 18,054.7 сая төгрөг зарцуулагдаж, зардлын гүйцэтгэл 81.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 2023 онд нийт 370.5 сая төгрөг зарцуулагдсан байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	УИХ-аас батлагдсан 2023 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт	8
Дүрслэл №2	Татварын орлогын төлөвлөгөө	8-9
Дүрслэл №3	Татварын бус орлогын төлөвлөгөө	9
Дүрслэл №4	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Дүрслэл №5	2023 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгаа	14

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2023 оны батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан судалгаа	9-10
Хүснэгт 2	2023 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	11
Хүснэгт 3	2023 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл нэр, төрлөөр	11
Хүснэгт 4	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр өмнөх онтой харьцуулсан судалгаа	13
Хүснэгт 5	Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	14
Хүснэгт 6	2023 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгаа	14
Хүснэгт 7	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 8	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15
Хүснэгт 9	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа	15-16
Хүснэгт 10	ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардал	16
Хүснэгт 11	2022 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал /аймаг, сумдаар/	16
Хүснэгт 12	УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсөв	17
Хүснэгт 13	Аймгийн 2023 оны тодотгосон төсөв	18-19
Хүснэгт 14	Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэл /зардлын зүйл ангиар /	20
Хүснэгт 15	Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	22-23
Хүснэгт 16	Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	25-26
Хүснэгт 17	Орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	26

БҮЛЭГ 1

Орон нутгийн 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж
биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна.

1.1. Орон нутгийн 2023 оны төсөвт татварын болон татварын бус 10 нэр төрлийн орлогыг 1,650.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 66.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдаж, Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8031 дүгээр албан бичгээр УИХ-аас батлагдсан төсвийг ирүүлсэн байна. Орон нутгийн 2023 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг дурдсан байна. Үүнд:

- Экспортыг эрчимжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, дэмжих, тэдгээрийн тээврийн үйл ажиллагааг саадгүй явуулахад онцгой анхаарч ажиллах
- Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, мөн харьяа татварын албатай хамтран татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын бүртгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулах
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогын нийлбэр дүнд шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах, тооцоолох ажлыг харьяа татварын албатай хамтран зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах
- Хүү, торгуулийн орлогыг нэр төрөл бүрээр бүртгэн, гүйцэтгэлийг төвлөрүүлэгч байгууллага бүрээр гаргах
- Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх
- Татварын ерөнхий хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ гүйцэтгэгч татварын албанд татварын өртэй тохиолдолд улсын төсвийн санхүүжилтээс татварын өрд суутган тооцох ажлыг үргэлжлүүлэх
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-д “аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасан Сангийн яам хянасан орлогыг нэмэгдүүлэхгүй байх
- Албан татвар төлөгч иргэний худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувийн буцаан олголтоос авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, автын агаарын бохирдлын төлбөр, зам ашигласны төлбөр, замын торгууль, хураамж, галт зэвсгийн албан татвар, газрын төлбөр, малын тоо толгойн албан татварт суутгуулах хүсэлтийг харьяа татварын албатай хамтран зохион байгуулах
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасан бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогыг хураахтай холбоотой хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.-д заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоол гаргах
- “Үл хөдлөх эд хөрөнгө”-ийн тооллого, бүртгэлийг улсын бүртгэлийн байгууллага тулган баталгаажуулж татварт хамрагдаагүй үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжийг татварт хамруулах ажлыг харьяа татварын албатай хамтран хэрэгжүүлэх


- Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөл эзэмшигчийн талаар мэдээлэл бүртгэлийн санг үүсгэн баяжуулж, харьяалах татварын албанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлэх
- Төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын ногдол, өрийг барагдуулах ажилд хамтарсан удирдамж батлуулан ажиллан дэмжлэг үзүүлэн ажиллах

Аймгийн СТСХ-ээс төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг ирүүлээгүй байна.

2023 оны орон нутгийн төсвийн орлого төлөвлөлтийн талаар:

2023 онд УИХ-аас анх батлагдсан 8,134.4 сая, тодотголоор батлагдсан 9,033.3 сая төгрөгийн орлогыг аймаг, сумдын ИТХ-аар 1,584.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлого 10,617.8 сая төгрөг төвлөрүүлэхээр батлуулсан байна.

УИХ-аас батлагдсан 2023 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг дүрслэлээр харуулбал:




Эх сурвалж: 2023 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дүрслэлээс харахад: УИХ-аас батлагдсан орлогын дүнг аймгийн ИТХ-ын тогтоолоор 17.5% буюу 1,584.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал, Орон нутгийн татварын орлогыг 1,182.2 сая төгрөгөөр буюу 14.6%-аар, татварын бус орлогыг 43.2% буюу 402.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөж баталсан байна.


Татварын орлогын төлөвлөгөөнд 7 нэр, төрлийн орлогыг 1,248.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр, төрлийн орлогыг 66.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Дүрслэл №2

Нэмэгдүүлэн баталсан орлогыг
нэр, төрлөөр нь харуулбал:



Бууруулан баталсан орлогыг
нэр, төрлөөр нь харуулбал:



Орлого нэмэгдүүлж төлөвлөсөн шалтгааныг тодруулбал:


- Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлогыг төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэхтэй холбоотой нэмэгдүүлсэн
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж Сүмбэр сум өмнөх оны авлагад үндэслэн 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
- Дуудлага худалдааны орлогыг гүйцэтгэлд үндэслэн 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
- Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийг БОАЖЯ-аас өгсөн зөвшөөрлийн дагуу нэмж төлөвлөсөн
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг өмнөх оны өр болон Татварын хэлтсээс ирүүлсэн саналд үндэслэн нэмэгдүүлсэн
- Малын тоо толгойд ногдуулах албан татварыг сумдын ИТХ-аар нэмж төлөвлөсөн

Орлого бууруулж төлөвлөсөн шалтгааныг тодруулбал:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Улсын тэмдэгтийн хураамжийг төлөвлөхөд хүндрэлтэй тул гүйцэтгэл, тооцоололд үндэслэн бууруулж баталсан

Татварын бус орлогын төлөвлөгөөнд 3 нэр төрлийн орлогыг 402.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Дүрслэл №3



- Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг Усан спорт сургалтын төв 30.0 сая, авто замын сан 20.0 сая, СДОА 20.0 сая, нийт 70.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ЦСҮТ-ийн орлогыг 10.3 сая төгрөгөөр бууруулсан
- Хүү, торгуулийн орлогыг орлогын нэр төрөл бүрээр төлөвлөөгүй, 2022 оны гүйцэтгэлд үндэслэн 60.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн
- Сумдын ХХС 283.3 сая төгрөгөөр төлөвлөсөн

2023 оны батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2022 оны батлагдсан орлого	2023 оны батлагдсан орлого	Зөрүү
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	5,171.6	5,794.7	623.1
2	ХХОАТ-ын буцаан олголт	(263.9)	(317.9)	(54.0)
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	740.0	801.3	61.3
4	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	130.0	140.0	10.0
5	Улсын тэмдэгтийн хураамж	111.2	80.0	(31.2)
6	Газрын төлбөр	389.0	499.9	110.9
7	Ус ашигласны төлбөр	581.0	787.0	206.0
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	20.0	40.0	20.0
9	Дуудлага худалдааны орлого	10.0	400.0	390.0
10	Хөрөнгийн орлого	248.0	250.0	2.0
11	Хөрөнгө борлуулсны орлого	150.0	100.0	(50.0)
12	Шууд бус орлого	300.0	0.0	(300.0)
13	Үйл ажиллагааны орлого	40.0	50.0	10.0
14	Бууны албан татвар	4.9	5.0	0.1
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	20.0	-

16	Хог хаягдлын хураамж	162.0	185.0	23.0
17	Малд ногдуулах албан татвар	144.2	148.8	4.6
18	ААН-ийн орлогын албан татвар	160.0	300.0	140.0
Татварын орлогын нийт дүн		8,118.0	9,283.8	1,165.8
1	Түрээсийн орлого	60.0	60.0	-
2	Хүү, торгуулийн орлого	840.3	900.0	59.7
3	Төсөвт байгууллагын өөрийн орлого	82.6	90.7	8.1
4	Бусад орлого	64.0	0.0	-64.0
5	Сумдын ХХС орлого	126.5	283.3	156.8
Татварын бус орлогын нийт дүн		1,173.4	1,334.0	160.6
Нийт орлогын дүн		9,291.4	10,617.8	1,326.4

Эх сурвалж: 2022, 2023 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: Өмнөх онтой харьцуулахад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 14.3% буюу нийт 1,326.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь улсын хэмжээнд цалингийн доод хэмжээ шинэчлэгдэн нэмэгдсэн, дуудлага худалдааны орлогыг нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Аудитаар 2023 оны төсвийн орлого төлөвлөлттэй холбоотойгоор төлөвлөгөө, татварын орлогын мэдээ, аймгийн СТСХ, Татварын газраас ирүүлсэн шалтгаан, тайлбарыг үнэлж үзэхэд дараах асуудлууд илэрсэн байна. Тухайлбал,

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогыг төлөвлөхдөө “Шивээ овоо” ХК-ийн өмнөх оны өрийг оруулж тооцоолоогүй
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, галт зэвсэг эзэмшигчийн бүртгэл зөрүүтэй

1.2. Орон нутгийн 2023 орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 18.5% буюу 1,969.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн татварын орлого 366.2 сая, 3 нэр төрлийн татварын бус орлого 43.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Нийт орлого:


2023 онд орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлогод нийт 10,617.8 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12,587.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 1,969.6 сая төгрөг буюу 18.5%-аар давж биелсэн байна.

Татварын орлого:

2023 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Он	Татварын орлого				/сая төгрөгөөр/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь	
2023	9,283.8	10,865.3	1,581.5	117.0	
2022	8,118.0	8,527.5	409.5	105.0	

Дүрслэл №4



Дүрслэлээс харахад: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 14.4%-аар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба өмнөх оны гүйцэтгэлээс 27.4%-аар өссөн байна. 2022 онд орлогын төлөвлөгөө 5.0%-иар давж биелсэн бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 17.0%-аар давж биелсэн байна.

2023 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр, төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	5,794.7	7,316.0	1,521.3	126.3
Үйл ажиллагааны орлого	50.0	110.8	60.8	221.6
Хөрөнгийн орлого	250.0	290.4	40.4	116.2
Хөрөнгө борлуулсны орлого	100.0	209.9	109.9	210.0
Шууд бус орлого	0.0	59.7	59.7	100.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	317.9	317.9	0.0	100.0
ААН-ийн орлогын албан татвар	300.0	391.4	91.4	130.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	801.3	708.1	93.2	88.4
Бууны албан татвар	5.0	4.5	0.5	89.4
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	140.0	129.5	10.5	92.5
Малын тоо толгойд ногдуулах албан татвар	148.8	90.9	57.9	61.4
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	141.4	61.4	176.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	43.7	23.7	218.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	185.0	171.2	13.8	92.5
Газрын төлбөр	499.9	317.2	182.7	63.5
Дуудлага худалдаа	400.0	392.4	7.6	98.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.0	55.5	15.5	138.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	787.0	750.5	36.5	95.4
Нийт дүн	9,283.8	10,865.3	1,581.5	117.0

Эх сурвалж: 2023 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 1,581.5 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: 10 нэр төрлийн орлого 0.4-2 дахин буюу 15.5-1,521.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн бол 8 нэр төрлийн орлого 1.9-38.6%-аар буюу 0.5-182.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулахад:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогын төлөвлөгөө давсан нь төрийн албан хаагчдын цалин хөлс 2023.07.01-нээс нэмэгдсэн, “Шивээ овоо” ХК-ны өмнөх оны 828.1 сая төгрөгийн өр төлөгдсөн
- Үйл ажиллагааны орлого давсан нь газрын эрх борлуулсны 37.6 сая, ХХААХҮС-ын А/675 дугаар тушаалаар 9.7 сая төгрөгийн ноос, арьс, ширний урамшууллын татварыг суутгасан
- Хөрөнгө борлуулсны орлого давсан нь 1,300.0 сая төгрөгийн үл хөрөнгө худалдан борлуулснаас шалтгаалсан
- Шууд бус орлогыг төлөвлөөгүй
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого давсан нь ШШПГ-аас 1 татвар төлөгчтэй холбоотой 90.0 сая төгрөг төлөгдсөн

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр давсан нь Шивээговь сумын авто зам болон спортын талбайн засварт ашигласан элс хайрганы төлбөр төлөгдсөн

Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгааныг аймгийн СТСХ, Татварын газраас тодруулбал:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар тасарсан нь үйл ажиллагаа зогссон татвар төлөгчдийн өр төлөгдөөгүй
- Бууны албан татвар галт зэвсгээ цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн, нас барсан иргэдийн татвар төлөгдөөгүй
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар тасарсан нь Авто тээврийн үндэсний төв сүүлийн 5 жил хөдөлгөөнд оролцоогүй, эзэн холбогдогч тодорхойгүй, эвдэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийг тусгаарласнаас татвар төлөгдөөгүй
- Шивээговь, Баянтал сумдын малын тоо толгойн албан татварын хэрэгжилт 29.9-44.4 хувьтай
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж нь Шивээговь сум, Сүмбэр сумын төмөр замын оршин суугчдын хураамж төлөлт хангалтгүй
- Газрын төлбөр нь Шивээговь сумын нутагт эзэмшил бүхий 1 татвар төлөгчийн газар маргаантай улмаас төлөгдөөгүй
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр “Шивээ овоо” ХК-ийн 36.5 сая төгрөгийн өр төлөгдөөгүй

Аудитаар орлогын гүйцэтгэлтэй холбоотойгоор орлогын гүйцэтгэл, татварын орлогын мэдээ, аймгийн СТСХ, Татварын газраас ирүүлсэн шалтгаан, тайлбарыг үнэлж үзэхэд дараах асуудлууд илэрсэн байна. Тухайлбал,

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогыг төлөвлөхдөө “Шивээ овоо” ХК-ны өмнөх оны өрийг оруулж тооцоолоогүй
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, галт зэвсэг эзэмшигчийн бүртгэл зөрүүтэй
- Бууны албан татварын орлогын төлөвлөгөө сүүлийн 5 жилд 0.2-1.6 сая төгрөгөөр жил бүр тасарсан
- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө сүүлийн 2 жилд 51.5-61.4 хувиар тасарсан
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөө Шивээговь, Баянтал сумдад тасарсан

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2022 он		2023 он		Зөрүү	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	5,171.6	5,459.6	5,794.7	7,316.0	-623.1	-1,856.4
2	ХХОАТ-ын буцаан олголт	(263.9)	(263.9)	(317.9)	(317.9)	(54.0)	(54.0)
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	740.0	559.6	801.3	708.1	(61.3)	(148.5)
4	АТБӨЯХ-ийн албан татвар	130.0	135.0	140.0	129.5	(10.0)	5.5
5	Улсын тэмдэгтийн хураамж	111.2	67.9	80.0	141.4	31.2	(73.5)
6	Газрын төлбөр	389.0	278.4	499.9	317.2	(110.9)	(38.8)
7	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	581.0	367.2	787.0	750.5	(206.0)	(383.3)

8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	20.0	0.0	40.0	55.5	(20.0)	(55.5)
9	Дуудлага худалдааны орлого	10.0	645.8	400.0	392.4	(390.0)	253.4
10	Хөрөнгийн орлого	248.0	260.8	250.0	290.4	(2.0)	(29.6)
11	Хөрөнгө борлуулсны орлого	150.0	108.2	100.0	209.9	50.0	(101.7)
12	Шууд бус орлого	300.0	368.7	0.0	59.7	300.0	309.0
13	Үйл ажиллагааны орлого	40.0	98.3	50.0	110.8	(10.0)	(12.5)
14	Бууны албан татвар	4.9	4.7	5.0	4.5	(0.1)	0.2
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	19.1	20.0	43.7	0.0	(24.6)
16	Хог хаягдлын хураамж	162.0	188.1	185.0	171.2	(23.0)	16.9
17	Малд ногдуулах албан татвар	144.2	70.0	148.8	90.9	(4.6)	(20.9)
18	ААН-ийн орлогын албан татвар	160.0	160.0	300.0	391.4	(140.0)	(231.4)
Татварын орлогын нийт дүн		6,017.1	8,118.0	9,283.8	10,865.3	(3,266.7)	(2,747.3)

Эх сурвалж: 2022, 2023 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгтээс харахад: Татварын орлого нийт дүнгээрээ өмнөх онтой харьцуулахад 3,266.7 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ба гүйцэтгэл 2,747.3 сая төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: өмнөх оноос татварын 14 нэр төрлийн орлогыг 0.1-623.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 31.2-50.0 сая төгрөгөөр бууруулж, төлөвлөсөн ба 1 нэр төрлийн орлого төлөвлөөгүй байна. Гүйцэтгэлээр 13 нэр төрлийн орлого 12.5-1,856.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 5 нэр төрлийн орлого 5.5-309.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим орлогын төлөвлөгөө өмнөх оны дүнгээс давж биелсэн нь урьд оны өр төлбөр төлөгдсөн, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тухайлбал: Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 828.1 сая /Шивээ овоо ХК-ийн өмнөх оны өр төлбөр барагдуулсан/

Татварын бус орлого:

2023 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 931.6 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 402.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,334.0 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2022	1,173.5	1,280.3	109.1
2023	1,334.0	1,722.1	129.1

Хүснэгтээс харахад: 2023 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 13.7% буюу 160.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд гүйцэтгэлээр тайлант оны орлогын төлөвлөгөөг 29.1%-аар давуулан биелүүлсэн байна.

2023 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

/сая төгрөгөөр/


Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын бус орлого		1,334.0	1,722.1	(388.1)
2.1.	Хүү, торгуулийн орлого	900.0	1,251.4	(351.4)
2.2.	Түрээсийн орлого	60.0	51.2	8.8

2.3.	Төсөвт байгууллагын өөрийн орлого	90.7	70.3	20.3
2.4.	Сумдын ХХС орлого	283.3	268.8	14.5
2.5.	Бусад орлого	0.0	80.4	(80.4)

Хүснэгтээс харахад татварын бус орлого нийт дүнгээрээ 388.1 сая төгрөгөөр давж биелсэн боловч түрээсийн орлого 8.8 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 20.3 сая, сумдын ХХС-гийн орлогын төлөвлөгөө 14.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2023 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгааг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №5



Дүрслэлээс харахад: Өмнөх онтой харьцуулахад МХГ-ын орлого, татварын хяналт, торгуулийн орлого 19.2-79.6 сая төгрөгөөр тус тус буурсан, төсөвт газрын өөрийн орлого 18.5 сая, ЦХ-ийн хүү торгуулийн орлого 108.5 сая, бусад нэр заагдаагүй орлого 353.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2022 онд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 31.6 сая төгрөгөөр баталсан ба аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 51.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 82.6 сая төгрөгөөр батлуулсан байна. Автозамын сангийн орлогыг 20.0 сая, Усан спорт сургалтын төвийн орлогыг 18.0 сая, СДОА-гийн орлогыг 13.0 сая төгрөгөөр нэмж батлуулсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2023 он		2022 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	АЗДТГ	0.7	1.3	0.7	17.9
2	УССТ	30.0	30.7	18.0	18.7
3	Цөм сүрэг үржлийн төв ОНӨҮГ	20.0	8.2	30.9	9.8
4	Авто зам	20.0	20.1	20.0	21.7
5	СДОА	20.0	10.1	13.0	13.0
Дүн		90.7	70.3	82.6	81.1
Сумдын сангийн орлого					
1	Сумдын Хоршоо хөгжүүлэх сан	283.3	268.8	126.5	262.2
Дүн		283.3	268.8	126.5	262.2
НИЙТ ДҮН		374.0	339.1	209.1	343.3

Хүснэгтээс харахад: 2023 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 78.8%-аар буюу 164.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Энэ нь Сумдын сум хөгжүүлэх сангуудын орлогыг тухайн жилийн зээлийн эргэн төлөлтөд уялдуулж төлөвлөсөнтэй холбоотой юм.

Өөрийн орлогын төлөвлөгөө нийт 34.9 сая төгрөг буюу 9.3%-аар тасарсан байна. Тухайлбал: Цөм сүргийн үржлийн төв 11.8 сая, Сум дундын ойн анги 9.9 сая, Сумдын Хоршоо хөгжүүлэх сангуудын орлого 14.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2023 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг анх 2,112.2 сая төгрөгөөр батлагдсан боловч төсвийн тодотголоор 266.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,378.2 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 /сая төгрөгөөр/

Он	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2023	2,378.2	2,378.2	-
2022	1,376.5	1,376.5	-

Тус аймаг нь 2022 онд улсын төсвөөс 1,376.5 сая, тайлант онд улсын төсвөөс 2,378.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба өмнөх онтой харьцуулахад 72.7%-аар өссөн байна.

2023 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгт дотоодын газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь, АМНАТ-ийн хуваарилалт 10 хувь, АМХТЗ-ийн 50 хувь, АМАТЗ-ийн 50 хувь, ОУБ-аас сумдын ОНХС-д олгох урамшуулал, нийт 5,731.5 сая төгрөгөөр батлагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

Он	ОНХНС-ийн санхүүжилт			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2023	5,731.5	5,643.2	88.3	98.5
2022	3,205.1	3,205.1	0.0	100

Хүснэгтээс харахад: 2023 онд ОНХНС-аас олгох санхүүжилт өмнөх оноос 78.8%-аар нэмэгдэж батлагдсан ба гүйцэтгэлээр санхүүжилтийг 1.5% буюу 88.3 сая төгрөгөөр дутуу авсан байна.

ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10 /сая төгрөг/

Д/д	ОНХС-гийн нэр	2022 оны ОНХС-ийн дансны үлдэгдэл	Эхний үлдэгдлээс санхүүжихээр баталсан	Зөрүү
1	Аймгийн ОНХС	290.6	290.6	0.0
2	Сүмбэр сумын ОНХС	252.2	252.2	0.0
3	Баянтал сумын ОНХС	97.8	97.8	0.0
4	Шивээговь сумын ОНХС	65.0	65.0	0.0
Нийт дүн		705.6	705.6	0.0

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг нийт 705.6 сая төгрөгөөр бүрэн баталсан байна.

2022 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлыг аймаг, сумдаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11 /сая төгрөг/

Д/д	Аймаг, сумдын нэр	2022 оны		Нийт дүн
		Давсан орлого	Хэмнэгдсэн зардал	
1	Аймаг	329.0	1,547.9	1,876.9

2	Сүмбэр сум	464.1	69.0	533.1
3	Баянтал сум	-	12.1	12.1
4	Шивээговь сум	-	118.9	118.9
Нийт		793.1	1,747.9	2,541.0

Хүснэгтээс харахад: 2022 онд 2,541.0 сая төгрөгийн давсан орлого, хэмнэгдсэн зардал байна. Нийт давсан орлого, хэмнэгдсэн зардлын 73.9%-ийг аймаг, 21%-ийг Сүмбэр сум, 0.5%-ийг Баянтал сум, 4.6%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

БҮЛЭГ Б

Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагыг бодитой тооцоогүй, ОНХС-гийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь төсвийн үр ашгийг бууруулж байна.

Б.1 Төсвийн зарлагыг бодитоор тооцож төлөвлөөгүйгээс төсөвт тодотгол хийсэн байна.

Сангийн сайдын 2022 оны 01/8031 тоот албан бичгээр орон нутгийн 2023 оны төсвийн төслийг хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийг хүргүүлсэн байна.

1. ИТХ-ын төлөөлөгчидтэй холбоотой зардлыг төсөвлөхгүй байх
2. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Засгийн газрын 2019 оны 389-р тогтоолын 3-р хавсралтын дагуу Төрийн захиргааны албан хаагчийн орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, хотоос орон нутагт шилжин суурьших зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20-100 хувиар олгох
3. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг орон нутагт шилжүүлэх
4. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож орон нутгийн суурь зарлагад төсөвлөсөн.
5. Авто замын сангийн эх үүсвэрийг хуульд заасан хэмжээгээр суурь зарлагад төсөвлөсөн.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсөв хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхдээ баримталсан чиглэлийн биелэлтийг аудитын явцад гаргаж ирүүлээгүй байна.

2023 оны орон нутгийн төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8031 тоот албан бичгээр Говьсүмбэр аймгийн төсвийг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Засаг даргад хүргүүлжээ.

УИХ-аас төсвийн суурь орлогыг 8,134.4 сая, суурь зарлагыг 10,246.5 сая, улсын төсвөөс олгох татаас 2,112.1 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 4,632.4 сая нийт 14,878.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор УИХ-ын баталсан төсвийг 4,698.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12

/сая төгрөгөөр/

		2023 онд батлагдсан төсөв		
Д/д	Зардлын төрөл	УИХ-аар батлагдсан	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн баталсан. 2022-12 сар	Зөрүү
1	Орон нутгийн суурь зарлага	10,246.5	12,313.7	2,067.2
2	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	4,632.4	5,376.6	744.2
3	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	-	1,363.7	1,363.7

4	Сумдын СХС-гийн зарлага	-	523.5	523.5
	Нийт дүн	14,878.9	19,577.5	4,698.6

Орон нутгийн 2023 оны төсвийг батлахдаа УИХ-аас баталсан төсвийг 1,010.2 сая төгрөгөөр бууруулж 5,708.8 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Үүнд:

Бууруулж баталсан зардлыг байгууллагаар нь авч үзвэл-1,010.2 сая :

- Цөм сүргийн үржлийн төв (15.0 сая)
- Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн засвар (364.9 сая)
- Соёл, Боловсрол, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардал (578.8 сая)
- Хот тохижилт, БХНСАХЗардал (51.5 сая)

Нэмэгдүүлж баталсан зардлыг байгууллагаар нь авч үзвэл:

- Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт 1,363.7 сая
- Сумдын ЗДТГ 1,118.0 сая
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 444.8 сая
- Аймгийн Засаг даргын Тамгын газар 705.4 сая
- Сумдын ХХС 523.5 сая
- Аймаг, сумын ОНХС 744.2 сая
- Бусад төсвийн байгууллага 809.2 сая

Сумдын ХХС, ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг УИХ-аас баталсан суурь зарлагад оруулан тооцдоггүйтэй холбоотойгоор 1,267.7 сая, орон нутгийн хөрөнгө оруулалт 1,363.7 сая, төсвийн байгууллагуудын цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой 1,087.5 сая, аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 205.4 сая, бусад урсгал зардалд 127.0 сая төгрөгийг тус нэмэгдүүлж баталсан.

Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлтээр Орон нутгийн 2023 оны төсөвт тусгагдсан хууль, дүрэм журамд нийцээгүй 405.7 сая төгрөгийн зарлагыг бууруулах санал хүргүүлснээс 107.3 сая төгрөгийн саналыг хүлээн зөвшөөрч зардлыг бууруулсан, 203.5 сая төгрөгийг хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулж, 94.4 сая төгрөгийг батлагдсан нормоос хэтэрсэн шатахуун, дотоод албан томилолт, биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаар баталжээ. Үүнд:

1. Аймгийн ИТХурал

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1¹, 31.1.3², Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3³, Засгийн газрын 2019 оны 445-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын 3.4.4⁴-т заасны дагуу төлөвлөөгүй 5.6 сая төгрөгийн тээвэр шатахуун, 8.0 сая төгрөгийн дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, 7.0 сая төгрөгийн биеийн тамир, уралдаан тэмцээний зардал, 25.0 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардал **нийт 45.6 сая төгрөг**

2. Аймгийн ЗДТГГазар

- Дотоод албан томилолтын зардлын тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс илүү гарсан 4.2 сая, орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлалын дагуу төлөвлөөгүй тээвэр шатахууны 9.6 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

³ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

⁴ тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

*чиг үүрэгт хамааралгүй төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зардлыг
санхүүжүүлэх 35.0 сая, **нийт 48.8 сая төгрөг***

Төсвийн хөрөнгө оруулалтын саналд “аймгийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй” 122.0 сая төгрөгийн 2, “Урсгал зардлын тооцоо, орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчлөлийн асуудлын талаар дүгнэлт гаргаагүй” 1,206.6 сая төгрөгийн 6 нийт 1,328.6 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээний зөрчлийг арилгуулж хууль тогтоомжид нийцүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.08.04-ний өдрийн 03, Сүмбэр сумын ИТХ-ын хуралдааны 2023.08.14-ний 03, Шивээговь сумын ИТХ-ын хуралдааны 2023.09.04-ний 06, Баянтал сумын ИТХ-ын хуралдааны 2023.08.23-ны 06 дугаар тогтоолоор суурь зарлагыг 1,085.8 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 168.2 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 1,382.6 сая, сумдын ХХС-гийн зарлагыг 9.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт 22,223.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2023 оны тодотгосон төсвийг хүснэгтээр харуулбал
Хүснэгт №13 /сая төгрөгөөр/

Д/д	Зардлын төсөв	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
1	Орон нутгийн суурь зарлага	12,313.7	13,399.5	1,085.8
2	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	5,376.6	6,759.2	1,382.6
3	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	1,363.7	1,531.9	168.2
4	Сумдын СХС-ийн зарлага	523.5	533.0	9.5
	Нийт дүн	19,577.5	22,223.6	2,646.1

Хүснэгтээс харахад зарлагыг анх батлагдсан дүнгээс 2,646.1 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар нэмж баталсан байна.

Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих дүн 1,099.1 сая төгрөг болж нэмэгдсэн.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг өмнөх оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас 66.2 сая, орон нутгийн төсвийн орлогоос 102.0 сая нийт 168.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Төсвийн байгууллагуудын суурь зарлага буюу цалин хөлс, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, дотоод албан томилолт, улсын төсвийн байгууллагад ажиллаж буй орон нутгийн төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд нийт 1,085.8 сая төгрөгийг төсөвт нэмж тусгажээ.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд 2023 оны 06 сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна.

Аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁵, 34.2.1⁶, 34.2.2⁷, 34.2.3⁸-т заасныг зөрчиж төсөвт тодотгол хийх шаардлага үүсээгүй байхад 2023 оны 02 сарын 01-ний өдрийн 10 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийсэн бөгөөд хэмнэгдсэн зардал, давсан орлогыг 342.3 сая, татварын орлогыг 197.0 сая, шилжих хөрөнгө оруулалт 47.6 сая нийт 586.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сумдын төсвөөс авах татаасыг 15.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Энэ нь орон нутгийн төсвийн хэмнэгдсэн зардал, давсан орлого, шилжих хөрөнгө оруулалтын ажил, татварын орлогыг бодитоор тооцож батлуулаагүйгээс шалтгаалсан байна.

⁵ 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

⁶ 34.2.1.дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;

⁷ 34.2.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;

⁸ 34.2.3.энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах.

Аймаг, Баянтал сумын ИТХ тус бүр 2 удаа, Шивээговь, Сүмбэр сумын ИТХ тус бүр 3 удаа төсөвт тодотгол хийсэн боловч Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3⁹-т заасны дагуу иргэдийн оролцоог хангаж ажиллаагүй байна.

Б.2.2. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй нь төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд боловсролын 14, соёлын 5, эрүүл мэндийн 2 нийт 21 /тогтмол зардлын гүйцэтгэл/, орон нутгийн төсвийн 13, тусгай сан 9, аймгийн Засаг дарга данс 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт данс 1, Барьцаа данс 4, Орон нутгийн ерөнхий орлогын 4 нийт 52 дансны гүйцэтгэлийг нэгтгэсэн.

Тайлант онд 22,223.8 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс төсвийн гүйцэтгэл 81 хувь буюу 18,054.8 сая төгрөгийг зарцуулж 4,169.0 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Үүнээс 2,319.9 сая төгрөгийн хэмнэлт нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүйгээс үүссэн бодит бус хэмнэлт байна. Тухайлбал:

- ЦСҮТ ОНӨҮГ, 11.7 сая, Сум дундын ойн анги нь 10.0 сая, Шивээговь сум 79.6 сая нийт 101.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс холбогдох зардалд бодит бус хэмнэлт үүссэн.
- Аймаг, сумдын ОНХС, авто замын сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүйгээс 2,218.6 сая төгрөгийн бодит бус хэмнэлт үүссэн.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар хүснэгтээр харуулбал: Хүснэгт 14 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,223.8	18,054.8	4,169.0
УРСГАЛ ЗАРДАЛ	14,514.3	13,026.9	1,487.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,715.1	11,900.6	814.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,390.0	4,281.8	108.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	567.4	518.9	48.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,472.6	3,262.4	210.2
Хангамж, бараа материалын зардал	278.5	267.9	10.6
Нормативт зардал	3.4	3.0	0.4
Эд хогшил, урсгал засварын зардал	359.6	353.4	6.2
Томилолт, зочны зардал	154.9	137.1	17.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,371.5	1,213.9	157.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,117.1	1,862.2	254.9
ТАТААС	39.3	38.0	1.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	39.3	38.0	1.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,760.0	1,088.3	671.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,236.8	796.7	440.2
Бусад урсгал шилжүүлэг	523.2	291.6	231.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,176.5	4,909.4	2,267.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	533.0	118.4	414.6
Сум хөгжүүлэх сан	533.0	118.4	414.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,223.8	19,865.7	2,358.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,731.5	5,643.2	88.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,731.5	5,643.2	88.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,163.1	13,883.3	1,279.7
Орон нутгийн төсвөөс	15,163.1	13,883.3	1,279.7

⁹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,329.2	339.1	990.1
---------------------------------------	---------	-------	-------

2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлын гүйцэтгэл, хэмнэлтийн шалтгааныг харьцуулан судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал-156.7 сая төгрөгөөр хэмнэсэн нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалсан байна.
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал-210.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд аймгийн ЗДТГ 17.8 сая, Шивээговь сумын ЗДТГ 39.1 сая, БОАЖГ 12.4 сая, 5-р сургууль 28.2 сая, 5-р цэцэрлэг 25.5 сая, Политехник коллеж 23.0 сая, Сүмбэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилга ашиглалтад ороогүйгээс 25.5 сая төгрөгийн зардал тус тус хэмнэсэн нь тус тус нөлөөлжээ. АИТХ-ын 2023 оны 08 сарын 04-ний өдрийн 03-р тогтоолоор байр ашиглалттай холбоотой 147.5 сая төгрөгийн тогтмол зардлыг нэмж тодотгосон нь төсөв хэмнэгдэх шалтгаан болсон байна.
3. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж-157.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд АЗДТГ 138.2 сая төгрөг хэмнэсэн нөлөөлсөн бөгөөд 100.0 сая төгрөгөөр ХШҮ-ний программ хангамж худалдан авахаар төлөвлөсөн боловч хэрэгжээгүйтэй холбоотой байна.
4. Бараа үйлчилгээний бусад зардал 254.9 сая төгрөг хэмнэгдсэн. Үүнд: Авто замын сан 64.1 сая, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 31.9 сая, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 49.1 сая, Сүмбэр сумын ЗДТГ 60.9 сая, Шивээговь сумын ЗДТГ 42.3 сая төгрөгийн зардал хэмнэсэн нь нөлөөлжээ.
5. Засгийн газрын урсгал шилжүүлэг-440.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд аймгийн ОНХС 215.2 сая, Сүмбэр сумын ОНХС 88.9 сая, Шивээговь сумын ОНХС 130.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй тул хэмнэлт үүссэн байна.
6. Бусад урсгал шилжүүлэг-231.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд: Улсын төсвийн байгууллагад ажилладаг орон нутгийн төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл 62.4 сая, аймгийн ЗД-ын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал болон тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 150.4 сая, Халамжийн сан 13.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.
7. Хөрөнгийн зардал-2,267.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтын он дамжин хэрэгжих 4 ажлын 178.0 сая, гэрээний хэмнэлт 12.0 сая, аймаг, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ОНХС-гийн төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүйгээс он дамжсан 2,040.6 сая төгрөгөөр тус тус хэмнэлт үүссэн байна.
8. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл-414.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Сүмбэр сум 331.4 сая, Шивээговь сум 24.7 сая, Баянтал сум 58.3 сая төгрөгийн зээл олголт хийгдээгүйтэй холбоотой байна.

Төсвийн орлого, зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөснөөр төсвийн үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх боломжтой байна. Тухайлбал: 2023 оны зардлын хэмнэлтээс үүссэн 4,169.0 сая төгрөгөөс 1,849.1 сая төгрөг нь бодит хэмнэлт тул хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулах боломжтой байжээ.

Аудитаар аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой нийт 96.0 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 88.6 сая төгрөгийн 5 зөвлөмж, 7.4 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн байна.

- Сүмбэр сумын ИТХ: Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулаагүй буюу 1.9 сая төгрөгийг хоолны зардалд зарцуулсан.
- Сүмбэр сумын Засаг дарга: Төсвийн тодотголоор ЗДТГ, ИТХ-ны урсгал зардлыг 43.0 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан.
- Шивээговь сумын ХХС: Батлагдсан орлогын төлөвлөгөөг 1.3 сая төгрөгөөр биелүүлээгүй.
- Баянтал сумын Засаг дарга: Татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй, батлагдсан орлогын төлөвлөгөөг 41.4 сая төгрөгөөр биелүүлээгүй.
- Баянтал сумын ХХС: Хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад зориулах 0.8 сая төгрөгийн зардлыг "Сумын 30 жилийн ойн бүтээлч ажилд санал авах, явуулын ахуй үйлчилгээ, үүрэн телефоны үйлчилгээг малчдад хүргэх" зорилготой өдөрлөгийн үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан.

- Шивээговь сумын ЗДТГ: Сумын хог хаягдалд зарцуулах 4.9 сая төгрөгийн шатахууны зардлыг үндсэн үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан.
- Баянтал сумын ЗДТГ: Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж 2.5 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1¹⁰-т заасны дагуу төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг иргэдэд нээлттэй мэдээлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 215.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 155.4 сая, нийт 370.5 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 19.9 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 2.5 сая, хангамж, бараа материалын зардалд 6.3 сая, томилолт, зочны зардалд 0.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 74.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 129.9 сая, урсгал шилжүүлгийн зардалд 135.6 сая, хөрөнгийн зардалд 1.7 сая нийт 370.5 сая төгрөгийг зарцуулжээ.

БҮЛЭГ В

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хэрэгжилт 86.0 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 01 сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 90.6 хувьтай буюу тодорхой үр дүнд хэрэгжсэн гэж үнэлжээ.

Хүснэгт №15 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

		/сая төгрөгөөр/					
№	Хөтөлбөрийн		Суурь он	Баглагдсан төсөв /сая.төг/	Төсвийн гүйцэтгэл /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь	Эрх бүхий байгууллага ас хянасан түвшин
	Нэр	Код					
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	70105	2022	842.1	822.8	97.7%	98%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	70106	2022	3,153.3	2,759.7	87.5%	90%
3	Мэргэжлийн хяналт /СХДАА/	70417	2022	243.2	242.3	99.6%	93%
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх /ОНӨГ/	70426	2022	182.0	178.2	97.9%	92%
5	Хүрээлэн буй орчин /БОАЖГ, Ойн анги/	71411	2022	774.9	711.6	91.8%	95%
6	Мал аж, ахуйг хөгжүүлэх /Цөм сүргийн үржлийн төв/	70801	2022	170.0	158.3	93.1%	60%
7	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	70407	2022	100.0	100.0	100.0%	84%
8	Мал аж ахуйг хөгжүүлэх /Вакцин, ажил үйлчилгээний хөлс/	70801	2022	35.5	35.3	99.4%	92%

¹⁰ төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх

9	Соёл урлаг, спорт, аялал жуулчлал, коллеж /БТСГ, Боржигон чуулга, Музей Номын сан, коллеж/	71701, 71702, 71804	2022	979.7	938.2	95.8%	96%
10	Нийгмийн хамгаалал /Халамжийн сан, Ахмадын хороо/	72208	2022	100.0	86.1	86.1%	86%
11	Авто зам /Авто замын сан/	71101	2022	695.0	630.8	90.8%	91%
12	Авто тээврийн хяналт, зохицуулалт /Нийтийн тээвэр/	71105	2022	2.4	1.1	45.8%	46%
13	Усан хангамжийн татаас	71506	2022	36.9	36.9	100.0%	100%
14	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт /ОНХО, ОНХС/	70503	2022	4,630.4	3,514.8	75.9%	76%
Нийт				11,945.4	10,216.1	90.1%	86%

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын Б/56-р захирамж, CTCX-ээс ирүүлсэн судалгаа)

Хүснэгтээс харахад: ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 86 хувьтай хэрэгжсэн гэж үнэлжээ.

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ыг 60 хувьтай үнэлсэн нь тус байгууллага сүүлийн 3 жилийн хугацаанд өөрчлөлттэй /татгалзсан 2 -аудитад баримт материалыг гаргаж ирүүлээгүй шалтгаанаар, хязгаарлалттай 1 -материаллаг хэмжээний алдаа зөрчилтэй/ дүгнэлт авсан. Үндсэн үйл ажиллагаа болох цөм сүргийг өсгөх зорилт хэрэгжээгүйтэй холбоотой байна

АЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс орон нутгийн төсөв захирагчдын үйл ажиллагаанд Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” дагуу хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Харин аймгийн ИТХ, халамжийн сан, авто замын сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, нийтийн тээврийн татаас, ахмадын хороо гэх мэт хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийгээгүй байна. Цаашид аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс дээрх хөтөлбөрүүдийн биелэлтийг хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлттэй харьцуулан тайлагнаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэх шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4¹¹-т заасан танилцуулга, дүгнэлтийг гаргаж ирүүлээгүй байна.

¹¹ 54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

БҮЛЭГ Г

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 1,605.6 сая төгрөг буюу 47.7 хувь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил 23.0 сая төгрөг буюу 31 хувиар тус тус буурсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа 14 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,765.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 5 байгууллагад 6.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, 9 байгууллагад 1,759.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна. Өмнөх онд 3,364.9 сая төгрөгийн зөрчил илэрч 14 албан шаардлага өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулж байсан бол тайлант онд Шилэн дансны зөрчлийн дүн 47.7 хувиар буурчээ.

Говьсүмбэр аймгийн Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээ авч ажилласан байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу автомашины хэрэглээг хязгаарлаж, илүүдэлтэй тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулжээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/179 дүгээр захирамжаар албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий-4, албан ажлын-24, тусгай хэрэгцээний-28, нийт 56 авто машины жагсаалтыг гарган үүнээс 9 автомашиныг татан төвлөрүүлж дутагдалтай байгууллагад шилжүүлэх, бусад авто машиныг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргасан байна.

- Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй Grand Vitara маркийн /6100ГСА/ суудлын автомашиныг Баянтал суманд ашиглалтын гэрээгээр эзэмшүүлсэн.
- АИТХД-ын 2023 оны 113-р захирамжаар Боловсрол Шинжлэх ухааны газраас УАЗ-22069 маркийн /5557ГСА/ автомашиныг Орон нутгийн өмчийн газарт бүртгэж, 2024 оноос аймгийн Гэр бүл, хүүхдийн хөгжлийн газарт ашиглалтын гэрээгээр эзэмшүүлсэн.
- АИТХД-ын 2023 оны 115-р захирамжаар УАЗ-22069 маркийн /1813ГСА/ автомашиныг Биеийн тамир спортын газарт акталж, сэлбэг материалыг ашиглах зөвшөөрөл олгосон.
- УАЗ-22069 маркийн 1633ГСА, УАЗ-Пример маркийн 5096ГСА, Лексус-470 маркийн 1857ГСА, Грэйс маркийн 5695ГСА, Хьюндэй Старекс маркийн 5093ГСА, УАЗ-22069 маркийн 1058ГСА улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж 2023 онд 11.2 сая, 2024 онд 2.5 сая нийт 13.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2. Төсвийн зарлагыг санхүүжүүлэхдээ хэмнэлтийн бодлого баримтлан тэвчиж болох зардлуудыг хэмнэснээр 103.4 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Эд хогшлын зардлыг 6.2 сая, дотоод албан томилолтын зардлыг 17.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад бараа ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг-48.0 сая, аймгийн Засаг

даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг-31.5 сая, нийт 103.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад 10 байгууллагаас 10.2 сая төгрөгийн 14 зөрчил илэрч 5.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 1.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3.3 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

1. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”** гэж заасныг хэрэгжүүлээгүй дараах байгууллагуудад зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Үүнд:
“Аймгийн ИТХ, ЗДТГ, Сүмбэр сумын ИТХ, Орон нутгийн өмчийн газар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ”
2. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”** гэж заасныг хэрэгжүүлээгүй Засгийн газрын 2023 оны 52-р тогтоолоор олгосон урамшууллыг ажилласан хугацааны үр дүнг харгалзан олгоогүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. Үүнд:
“Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба”, “Шивээговь сумын ЗДТГ”
3. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ”** гэж заасныг аймгийн ЗДТГ хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх 1.8 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.
4. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”** гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй ЦСҮТ ОНӨҮГ, Шивээговь, Сүмбэр сумын ИТХ, Тохижилт Сүмбэр, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-т нийт 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

БҮЛЭГ Д

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй
хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар аймгийн Засаг даргад 3 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 76.6 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт №16

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилт	Хувь
1	Орон нутгийн өмчийн түрээсийн төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох, татварын суурийг нэмэгдүүлэх замаар орлого нэмэгдүүлэх санаачилга гаргах	Орон нутгийн өмчийн түрээсийн төлбөрийн хэмжээ, тарифыг шинэчлэн боловсруулж аймгийн ЗД-ын зөвлөлийн хурлаар дэмжигдээгүй, татварын суурь /ААНБ/- тоо 698-752 болж өмнөх оноос нэмэгдсэн бөгөөд 2023 оны 10 сарын байдлаар татварын орлого 113.6 хувийн биелэлттэй байна.	50%
2	Төсвийн төслийг боловсруулахдаа аливаа өөрчлөлтийг багтаасан эцсийн байдлаар бэлтгэн ирүүлэх	Аймгийн Төсвийн төслийг жил бүрийн 11 сарын 20-ны өдрийн дотор холбогдох өөрчлөлт, зохицуулалтыг тусган АИТХ-д өргөн барьж хувийг Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	80%
3	Төсвийн төсөлд тусгасан тооцооллыг Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын дагуу боловсруулаагүй.	Аймгийн 2024 оны төсвийн төслийг УИХ, Сангийн яамнаас баталсан төсвийн хүрээнд боловсруулж, холбогдох зохицуулалтыг тусган бэлтгэж АИТХ-д өргөн барьсан.	100%
Нийт			76.6%

Орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 532.5 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 86.6 хувьтай байна.

Хүснэгт №17

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилт	Хувь
1	Татварын бус орлогыг үндэслэлтэй төлөвлөж, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, жил бүр татварын бус орлогын төлөвлөгөө тасарч байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх	Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын орлогын төлөвлөгөөг 30.9 сая төгрөгөөр баталсан байсныг зөвлөмжийн дагуу дахин тооцоолол хийж 20.0 төгрөг болгон бууруулсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд аймгийн ЗД-ын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг нарийвчилсан хяналт шалгалт хийж байна.	50%
2	Сумдын төсөв батлах тогтоолыг хянах, үндсэн тэнцлийн ашиг болон, эхний үлдэгдлийг бүрэн батлахгүй байгаа зөрчлийн давтан гаргахгүй байх	Аймаг, сумдын ИТХ-аар 2023 оны төсвийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн баталсан бөгөөд аймаг, сумдын дансны үлдэгдлийг 100 хувь бүрэн төсөвт тусгасан.	100%
3	Төсвийн зарлагын хязгаарыг баримталж, шаардлагагүй	УИХ-аар 2023.06.16-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2023 оны төсвийн нэмэлт өөрчлөлт,	70%

урсгал төлөвлөхгүй байх	зардлыг	нэмж	Засгийн газрын шийдвэрийн дагуу Төрийн албан хаагчдын цалин, зэрэглэл өөрчлөгдсөн. Тогтмол зардалд тодотгол хийх шаардлага тулгарсан бөгөөд зөвхөн шаардлагатай зардлыг тодотгож УИХ, ЗГ, СЯ-наас ирүүлсэн чиглэлийг баримталсан бөгөөд бусад зардлыг нэмэгдүүлж батлуулаагүй.
----------------------------	---------	------	--

Нийт

73.3%

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүн нь хангалтгүй байна.

1. Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын орлогыг 10.0 сая төгрөгөөр бууруулж 20.0 сая болгосон боловч тухайн онд 11.2 сая төгрөгөөр орлого тасарсан. Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийн эцсийн дүгнэлт, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар шийдвэр гаргаагүй.
2. Орон нутгийн өмчийн түрээсийн үнэ тариф, журмыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49-р тогтоолын дагуу шинэчлэн боловсруулж мөрдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Орон нутгийн өмчийн газраас үнэ тариф, журмын төслийг боловсруулсан боловч аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар дэмжигдээгүй.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой 2 зөвлөмж өгсөн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-А

Орон нутгийн 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна.

1. Орон нутгийн 2023 оны төсөвт татварын болон татварын бус 10 нэр төрлийн орлогыг 1,650.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 66.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна
2. Орон нутгийн 2023 орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 18.5 хувь буюу 1,969.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн татварын орлого 366.2 сая, 3 нэр төрлийн татварын бус орлого 43.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна

Бүлэг-Б

Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагыг бодитой тооцоогүй, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй нь төсвийн үр ашгийг бууруулж байна.

1. Төсвийн зарлагыг бодитоор тооцож төлөвлөөгүйгээс төсөвт тодотгол хийсэн байна.
2. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй нь төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

Бүлэг-В

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хэрэгжилт 86 хувьтай байна.

Бүлэг-Г

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 1,605.6 сая төгрөг буюу 47.7 хувь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил 23.0 сая төгрөг буюу 31 хувиар тус тус буурсан байна.

Бүлэг-Д

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга Г.Батсүурь танаа

1. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хангуулах Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.7-т заасныг хэрэгжүүлэх
2. Татварын бус орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49-р тогтоолын дагуу "Орон нутгийн өмчийг түрээслүүлэх журам, түрээсийн үнэ тариф"-ыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.